

БОЛЗОШГҮЙ НӨХЦӨЛД АРД ИРГЭДЭЭ ХАМГААЛАХ ХАМГААЛАЛТЫН ТОГТОЛЦОО

*Доктор, профессор П.Цэдэв
ДХИС-ийн магистрант ахмад Г.Балжинням*

Хураангуй:

Өнөөдөр дэлхий дээр дайн, дайн бүхий байдалд нэлээд улс орон байгаа бөгөөд цөмийн зэвсэгтэй орон гэхэд 10 гаруй, химийн зэвсэгтэй орон 30 гаруй, биологийн зэвсэг гэхэд дэлхий даяар тархаж байна. Чухамхүү цөмийн зэвсэг нэг цүнхэд, химийн зэвсэг хуруу шилэн дотор, биологийн зэвсэг захидлын дугтуй дотор багтаж, терроризмын аюул улс орон дамжин тархаж явна гэхэд хэлсдэхгүй.

Өнөөгийн нөхцөл байдлын аюулаас ард иргэдээ хамгаалах асуудал хурцаар тавигдсаар байна. Ийм үед хуучин байсан глобал асуудал болох иргэний хамгаалалт нь амин чухал сэдэв болох нь хэвээр байна.

Энэ хүрээнд орчин үеийн хөнөөх хэрэгслийн хөнөөл /цөм, хими, биологи/-ийн зэвсгээс ард иргэдийг хамгаалах тогтолцоо, судлаачдын судалгааны дүгнэлтийн талаар авч үзнэ.

Олон улсын Женевийн конвенцын баримт бичигт, иргэний хамгаалалтын тодорхойлолт, иргэний хамгаалалтын байгууллагуудын зорилго, үүргийг тодорхойлсон байдал, манай орны иргэний хамгаалалтын байгууллагын тогтолцоо, гүйцэтгэж байсан үүргийн талаар авч үзсний дээр цаашид хүн амаа хамгаалах тогтолцооны асуудлыг хөндсөн болно.

Түлхүүр үгс: Дайн, хөнөөх хэрэгсэл, иргэний хамгаалалт, тогтолцоо.

Үндсэн хэсэг

Батлан хамгаалахын сайд агсан Ш.Жадамбаа “Улс орны Батлан хамгаалах тухай асуудал бол төр, засгийн байнгын анхаарлын гол асуудал бөгөөд манай нийгэм, эдийн засгийн бүх салбарыг хамарч хэрэгждэг. Монголын айл өрх, иргэн бүртэй холбоотой чухал үйл хэрэг билээ” гэж үзсэн байдаг.

Өнөөдөр дэлхий дээр дайны халуун гал дүрэлзсээр л байна. Манайхан бүүр хэзээ ч ОХУ Украин улс хоорондоо дайтна гэж бодож төсөөлж байгаагүй байж болох юм. Тэгвэл одоо жил гаруй үргэлжилсэн энэ дайнд олон мянган цэрэг, иргэд дайны хөлд амь насаа алдаж байна. Одоо ОХУ Украины дайн хэзээ дуусах нь тодорхойгүй, бас ширүүсэх бол цөмийн зэвсэг хэрэглэхийг хэн ч үгүйсгэж чадахгүй байна.

Нөгөө талаар ОХУ хөрш Беларусь улсад тактикийн цөмийн зэвсгийн тусгай агуулахаа барьж дуусгана гэж саяхан ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин мэдэгджээ. Орос цөмийн зэвсэг хадгалах боломжтой “Искандер” цогцолборыг Беларусьт аль хэдийн хүлээлгэн өгсөн гэж В.Путин 2023 оны 4 дүгээр сарын нэгэнд “Россия-24” сувагт ярилцлага өгөхдөө хэлсэн байна. Түүний хэлснээр, “Бид цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх гэрээг зөрчихгүйгээр Беларусийн нутаг дэвсгэрт тактикийн цөмийн зэвсгийг байрлуулахаар тохиролцсон” гэж “TASS” агентлаг В.Путиний хэлснийг эш татан мэдээлсэн байна. Дараа нь В.Путин Орос улс тактикийн цөмийн зэвсэг тээвэрлэх чадвартай 10 нисэх онгоцоо Беларусьт байрлуулсан гэж хэлснийг “TASS” мөн уламжилжээ. Москва дөрөвдүгээр сарын эхээр баг бүрэлдэхүүнийг сургаж эхэлнэ гэж В.Путин хэлээд, Орос улс

Беларусь дахь тактикийн цөмийн зэвсгийг хадгалах агуулахыг долоодугаар сарын 1 гэхэд барьж дуусгана гэж мэдэгджээ. Хоёр Солонгос улсын хоорондын харилцааны байдал таагүй хэвээр л байна. Энэ байдлаас үзэхэд цөм, хими, биологийн аюул (дайн)-тай тэмцэхэд ард иргэдээ хамгаалах арга хэмжээ чухал болох тодорхой асуудал болжээ.

Дайн байлдаан үл хүсэгч, төвийг сахисан Швейцарь бол улс төрийн төвч бодлоготой, гэхдээ дайны байдал бий болбол ард иргэдээ хамгаалах бүрэн тогтолцоотой дэлхийд гайхагдсан орон билээ. Энэ улс пуужингийн довтолгооноос хүн ам нь бараг бүрэн хорогдох, далдлах байраар хамгаалагдаж, газар доор үйлдвэрлэл үйлчилгээ явуулж чадна. Өөрөөр хэлбэл, бүрэн утгаараа иргэдээ хамгаалах иргэний хамгаалалтын тогтолцоотой орон билээ. Болзошгүй нөхцөл дайны үед ард иргэдээ нэг бүрийн болон нийтийн хамгаалах хэрэгслээр хангах, нүүлгэн шилжүүлэх гэсэн үндсэн гурван аргаар хамгаалах бөгөөд иргэдээ зарлан мэдээлэл хүргэх, сургаж бэлтгэх гээд олон үйл ажиллагааг явуулдаг.

Судлаачдын судалгааны материалаас үзвэл, орчин үеийн хөнөөх хэрэгслийн хөнөөлийн үед иргэний хамгаалалтын системгүй бол хүн амын 30 хувь амьд үлдэх бөгөөд цацрагаас хамгаалах, далдлах байр ашигласан тохиолдолд 50 хувь, харин хамгаалах байгууламж ашиглаж, үүн дээрээ нүүлгэн шилжүүлэлтийн аргыг хослон хэрэглэж чадвал хүн амынхаа 80 гаруй хувийг хамгаалах боломжтой гэж үзсэн байдаг. Энэ байдал нь ард иргэдээ тогтолцоотой байхыг нотлон харуулж буй хэрэг мөн.

Зарим улс төрч, судлаач нар Зэвсэгт хүчин гэх байх. Миний хувьд тэгэж бодохгүй байна. Зарим нь Онцгой байдлын ерөнхий газар гэж хэлбэл лавтай энэ үүргийг гүйцэтгэж байгаа байгууллагын хуульд ийм ямар ч заалт байхгүй.

Монгол Улсын Зэвсэгт хүчний тухай хуульд “Зэвсэгт хүчний үндсэн чиг үүрэг нь эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн, халдашгүй дархан байдлыг гадны зэвсэгт халдлага, түрэмгийллээс өөрийгөө хамгаалах явдал мөн”⁵⁴ гэж тодорхойлон заасан бөгөөд энэ үүргээ л биелүүлнэ. Өөрөөр хэлбэл, улс орныхоо нутаг дэвсгэрийг хамгаалахад операц, байлдааны ажиллагаа л явуулна гэж ойлгож байна. Дайн, дайн бүхий байдлын үед Зэвсэгт хүчин дайсан эсрэг талтайгаа л байлдах болохоос иргэний хамгаалалтын үүргийг огтхон ч гүйцэтгэдэггүй юм. Харин тайван цагт “аливаа хөнөөх хэрэгслийн хөнөөлийн голомтод байгаа хүн ам, эд юмсыг аврах, хор уршгийг арилгах”⁵⁵, “гамшгийн үед аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох, хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх”⁵⁶ гэсэн заалттай энэ үүргээ биелүүлж байгаа.

Тэгвэл, улс орны төрийн бодлогын нэг үндэс нь дайн, дайн бүхий байдал үүссэн үед ард иргэдээ хамгаалах явдал мөн. Энэ үүргийг тухайн улс орны төрийн удирдлагын доор гүйцэтгэдэг үндсэн байгууллага нь иргэний хамгаалалтын байгууллага юм.

Чухамхүү манай оронд дайн, дайн бүхий байдал бий болсон тохиолдолд ард иргэдээ хамгаалах тийм иргэний хамгаалалтын систем алга байна гэхэд хилсдэхгүй. Улс орны иргэний хамгаалалтын систем нь хүн амаа хамгаалах аргатайгаа уялдсан тогтолцоотой байдаг юм. Женевийн конвенцын баримт бичигт, иргэний хамгаалалтын тодорхойлолт, иргэний хамгаалалтын байгууллагуудын зорилго, үүрэг, иргэний хамгаалалтын ажилтан гэж хэнийг хэлэх, түүний үүргийг хуульчлан тодорхойлсон байдаг.

Энэ конвенцид Иргэний хамгаалалт нь “Энгийн хүн амыг аюулаас хамгаалах дайны ажиллагааны буюу гамшгийн шууд хор уршгийг арилгахад түүнд туслах, түүнчлэн түүний

⁵⁴ Монгол Улсын Зэвсэгт хүчний тухай хуулийн 6.1 заалт

⁵⁵ Монгол Улсын Зэвсэгт хүчний тухай хуулийн 6.2.6 заалт

⁵⁶ Монгол Улсын Зэвсэгт хүчний тухай хуулийн 6.2.7 заалт

энх тунх аж төрөхөд шаардагдах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн хүмүүнлэг зорилтыг хэсэгчлэн буюу бүрэн биелүүлэхийг” хэлнэ⁵⁷.

Иргэний хамгаалалт нь анхааруулах (зарлан мэдээлэл), нүүлгэн шилжүүлэх, хоргодох байр гаргаж, тэднийг тохижуулах, гэрэл далдлах арга хэмжээ авах, аврах ажлууд, анхны тусламж, эмнэлгийн үйлчилгээ, гал түймэртэй тэмцэх, аюултай бүсийг илрүүлэх, онцлон тэмдэглэх, халдваргүй болгох болон эмнэлгийн хамгаалалтын бусад төстэй арга хэмжээ, байр сууц болон хангалтыг яаралтай олгох, гамшиг тохиолдсон бүсэд сэргээн босгох болон дэг журам сахиулахад яаралтай тусламж үзүүлэх, нийтийн ахуйн шаардлагатай үйлчилгээг яаралтай сэргээх, цогцсуудыг яаралтай оршуулах, энх тунх байхад зайлшгүй шаардлагатай үйлчилгээг яаралтай сэргээх, төлөвлөлт, зохион байгуулалтаар хязгаарлахгүй эдгээр зорилтуудыг хэрэгжүүлэхэд ажлаа чиглүүлдэг юм.

Иргэний хамгаалалтын байгууллага гэж иргэний хамгаалалт гэсэн дээрх тодорхойлолтын зорилтуудыг биелүүлэх зорилгоор дайтаж буй улс орны эрх бүхий байгууллагуудаас олгосон бүрэн эрх бөгөөд зөвхөн эдгээр зорилтыг биелүүлэх зорилготой байгууллагууд болон зохион байгуулалттай бусад нэгжийг хэлнэ⁵⁸ гэжээ.

Иргэний хамгаалалт нь хөнөөх хэрэгслийн хөнөөл, гамшиг, ослын аюулаас хүн ам, эд хөрөнгийг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээж босгох арга хэмжээний систем юм.

Манай орон тухайн үедээ ЗХУ (хуучин нэрээр) тусламжаар иргэний хамгаалалтын арга хэмжээг өөрийн орондоо хэрэгжүүлж чадсан юм. Тухайлбал, зарлан мэдээллийн системтэй, улсын удирдлагын байр, үйлдвэр, байгууллага бүр хоргодох, далдлах байртай, хүн нэг бүрийн хамгаалалтын хэрэгслээр хангагдсан, нүүлгэн шилжүүлэлтийн зам маршрут, хүлээн авах байр гээд боломжийн тоноглогдсон байртай байсан юм. Чухам ингэж байж л улс орон иргэдээ хөнөөх хэрэгслийн хөнөөл, томоохон аюулаас хамгаалж чаддаг байлаа. Харин өнөөдөр энэ арга хэмжээ байгаа юу гэвэл миний ойлгож байгаагаар бүрэн утгаараа байхгүй болсон гэж үзэж байна.

Харин *Монгол Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичигт* “Хүн амыг гамшиг, гэнэтийн бусад аюул, үй олноор устгах зэвсгийн хөнөөлөөс хамгаалах нь батлан хамгаалах үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг бөгөөд нэгдсэн төлөвлөлт, нэгдмэл тогтолцоотой байна”⁵⁹ гэж тодорхойлон заасан билээ.

Нөгөө талаа Монгол Улсын Зэвсэгт хүчний тухай хуульд “Дайны байдал зарламагц хилийн ба дотоодын цэрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын байгууллага зэвсэгт хүчний бүтцэд шилжиж, үүрэг гүйцэтгэнэ”⁶⁰ гэж заасан. Гэтэл ард иргэдээ хамгаалах арга хэмжээ нь тайван цагт хийгдэж бэлтгэгдэж байдаг болохоос дайны үед гүйцэтгэх нь цаг хугацаа алдсан үр дүн муутай ажил болно.

Манай оронд Монгол Улсын Их Хурлаар 1994 онд Иргэний хамгаалалтын тухай хуулийг батлуулан хэрэгжүүлж байсан бөгөөд Иргэний хамгаалалтын тухай сайн хууль, тогтолцоотой байсан билээ. Сайн гэдэг нь Монгол Улс иргэний хамгаалалтын даргатай (энэ үүргийг Монгол Улсын Ерөнхий сайд толгойлож байсан)-байж, хөнөөх хэрэгслийн хөнөөл,

⁵⁷ Женевийн конвенцын VI бүлэг 61-р зүйл “а” заалт 278 хуудас

⁵⁸ Женевийн конвенцын VI бүлэг 61-р зүйл “а” заалт 278 хуудас

⁵⁹ *Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс* 2.6 заалт

⁶⁰ Монгол Улсын Зэвсэгт хүчний тухай 2022 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан хуулийн 7.2 дахь заалт

гамшиг, ослын аюулаас хүн ам, эд хөрөнгийг урьдчилан сэргийлэх, аврах, учирсан хор уршгийг арилгах арга ажиллагаанд иргэдийг сургаж бэлтгэж байсан юм. Улмаар энэ хууль нь 2004 онд Гамшгаас хамгаалах хууль болж батлагдсанаар иргэдийг хөнөөх хэрэгслийн хөнөөлөөс хамгаалах явдал нь Батлан хамгаалах арга хэмжээнд орж, гамшиг, осолтой тэмцэх үүрэг нь Монгол Улсын шадар сайдын хүрээнд (Гамшигтай тэмцэх ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газарт) орж хоёр салсан бөгөөд иргэний хамгаалалт хэмээх нэр томьёо үндсэн үүрэг нь үндсэндээ алга болсон гэж болно.

Хөнөөх хэрэгслийн хөнөөлөөс иргэдийг хамгаалах үүрэг ОБЕГ-т одоогийн хуулиар байхгүй байгаа. Төрийн бодлогод ч нарийн тусгагдахгүй хаягдахад хүрч байна.

Тухайн оронд тохиолдсон гамшиг осол, сүйрлийн хор уригийг аргилгах арга хэмжээ нь гадны орны хүч хөрөнгөд тулгуурлаж болох хэдий талтай ч иргэний хамгаалалтын арга хэмжээ бол өөрийн орны зөв бодлого хүч хөрөнгөд л тулгуурлан хөгжих ёстой билээ.

Дүгнэлт

Монгол Улсад орчин үеийн хөнөөх хэрэгслийн хөнөөл тохилдохгүй, болохгүй гэх баталгаа одоогоор алга байна. Иргэний хамгаалалтын тогтолцоогүй улс орон бүр мөхөлд хүрч байсан түүх бий. Иймд Монгол төрийн бодлогод болзошгүй нөхцөлд ард иргэдээ хамгаалах систем үгүйлэгдэж байна. Өөрөөр хэлбэл, ард иргэдээ хамгаалах үндсэн үүрэг бүхий иргэний хамгаалалтын тогтолцоотой байх ёстой гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Ашигласан материал:

1. Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс, 2015
2. Монгол Улсын Батлан хамгаалах тухай хууль
3. Монгол Улсын Зэвсэгт хүчний тухай хууль
4. Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хууль
5. БХЭШХ, Цэргийн нэр томьёоны тайлбар толь, УБ., 2014
6. Гомбосүрэн Д, Монгол Улсын иргэний хамгаалалт, УБ., 1995
7. Паламдорж Ш нарын, Батлан хамгаалах стратеги, УБ., 2017
8. Паламдорж Ш нарын, Зэвсэгт хүчний стратеги, УБ., 2017
9. Паламдорж Ш, Цэргийн шинжлэх ухаан зэвсэгт хүчин, УБ., 2022
10. ОУУЗХ, МУЗН, Женевийн конвенц 1949 нэмэлт протоколууд, УБ., 1995
11. khulan@montsame.gov.mn